



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 31 өдөр

Дугаар 407

Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн Усан спорт
сургалтын төвийн эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2023 оны А/15 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 10 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 3,035,000.00 (гурван сая гучин таван мянган) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сонгинохайрхан дүүргийн Усан спорт сургалтын төв (Б.Мягмарсүрэн)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 2 нэр төрлийн 835,000.00 (найман зуун гучин таван мянган) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 1 нэр төрлийн 2,200,000.00 (хоёр сая хоёр зуун мянган) төгрөгийн хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 5,000.00 (таван мянган) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь болох 1,500.00 (мянга таван зуун) төгрөгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын төрийн сангийн 100200051024 тоот дансанд Сонгинохайрхан дүүргийн Усан спорт сургалтын төв (Б.Мягмарсүрэн)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА



Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сонгинохайрхан дүүргийн Усан спорт сургалтын төв

д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын үнийн санал	НӨХГ-ын мэргэжилтний дүгнэлт	ҮХХХХХ-н шийдвэр
1	Бичиг хэргийн төмөр шкаф шилэн	10	ш	5	440,000.00	2,200,000	2,200,000	0	Эвдэрсэн, зэвэнд идэгдэж цаашид ашиглагдахгүй болсон.	актлах	5,000.00	
2	Сандал /захирал/	10	ш	1	450,000.00	450,000	450,000	0	Хөлгүй болсон, цаашид ашиглагдахгүй болсон	актлах	актлах	
3	Хогийн сав Гадаа	10	ш	1	385,000.00	385,000	385,000	0	Эвдэрсэн.	актлах	актлах	
Тавилга эд хогшил						3,035,000.00	3,035,000.00				5,000.00	
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн						3,035,000.00	3,035,000.00					
Үүнээс. Худалдах хөрөнгө						2,200,000						
Устгах хөрөнгө						835,000.00						
Татан төвлөрүүлэх хөрөнгө					-							
Худалдсанаас олох орлого					5,000.00							
НӨХГ-т төвлөрүүлэх /30%/					1,500.00							